

Төсөл

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны ... дугаар сарын ...-
ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 57 дугаар зүйлийн 57.9, 57.10, Төрийн аудитын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Авлигын эсрэг хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6, Прокурорын тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, Улсын ерөнхий прокурор, түүний орлогч, Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга, Төрийн аудитын байгууллагын дарга, дэд даргаас бусад төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаалтны цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрийг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай” Улсын Их Хурлын 2011 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 36 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тогтоолыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

Монгол Улсын Их Хурлын 2018 оны
..... дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨНДӨР АЛБАН ТУШААЛТНЫ ЗЭРЭГ ЗИНДАА, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ
ТӨРИЙН АЛБАН ТУШААЛТНЫ ЗЭРЭГЛЭЛД ХАМААРАХ АЛБАН ТУШААЛТНЫ
ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ ТОГТООХ ИТГЭЛЦҮҮР

Албан тушаалтын зэрэг зиндаа, адилтгах албан тушаалтын зэрэглэл		Албан тушаалтын сарын цалингийн итгэлцүүр
1	ТӨ-I	2.68
2	ТӨ-II	2.02
3	ТӨ-III	1.55
4	ТӨ-IY, ТӨ- IYA	1.49
5	ТӨ-Y, ТӨ- YA	1.38
6	ТӨ-YI, ТӨ- YIA	1.32
7	Яамны төрийн нарийн бичгийн даргын албан тушаалтын сарын цалингийн хамгийн өндөр шатлал	1.00

--- ооо ---